Улаанбаатар хотын өрхийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлж буй артерийн гипертензитэй үйлчлүүлэгчдийн эмийн тогтвортой хэрэглээг судалсан нь

С.Балжинням[1], Д.Мягмарцэрэн[1]

[1]АШУҮИС, АУС, Өрхийн анагаах ухааны тэнхим

Үндэслэл: Хүн амын нас баралтын гол шалтгаан нь халдварт бус өвчлөлүүд болж, жилээс жилд тохиолдол нь нэмэгдсээр байна. ДЭМБ-н тооцоолсноор халдварт бус өвчлөлийн тэргүүлэх 10 шалтгаанд цус харвалт, зүрхний шигдээс бүртгэгдэж байгаа бөгөөд үүний томоохон шалтгаанд артерийн гипертензи багтаж байна. Манай орны хувьд артерийн гипертензийн тархалт, эрсдэлт хүчин зүйлс судлагдсан боловч эмчилгээний үр дүнгийн хяналт, эмийн тогтвортой хэрэглээ, түүнд нөлөөлөх хүчин зүйлүүдийг ӨЭМТ-ийн хүрээнд судлаагүй байгаа нь энэ судалгааг хийх үндэслэл болсон.

Зорилго: Улаанбаатар хотын ӨЭМТ-р үйлчлүүлж буй артерийн гипертензитэй үйлчлүүлэгчдийн эмийн тогтвортой хэрэглээг судлахад оршино.

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй: Судалгааг өрхийн эмнэлэгт суурилан аналитик судалгааны нэг агшингийн проспектив загварыг ашиглан 2019 оны 5-8 сарын хооронд хийж гүйцэтгэсэн. Энгийн санамсаргүй түүврийн аргаар Улаанбаатар хотын 9 дүүргийн 27 ӨЭМТ-ийн эмч нарыг хамруулж, 3 бүлэг 11 асуулт бүхий MAP үнэлгээ хийж, түүгээр үйлчлүүлж буй нийт 186 үйлчлүүлэгчдээс 4 бүлэг 36 асуулт бүхий Морицкийн асуумж авч, тус тус мэдээлэл цуглуулан STATA 12 программыг ашиглан үр дүнг тооцлоо. Үр дүнгийн p утга 0.05-аас бага байх тохиолдолд статистикийн хувьд ач холбогдолтой гэж үзсэн.

Үр дүн: Судалгаанд хамрагдсан эмч нарын дундаж нас (стандарт хазайлт) 28,9 (1.1) 85,2% (n=23)-ийг эмэгтэйчүүд эзэлж байна, Судалгаанд хамрагдсан нийт эмч нарыг MAP аргаар үнэлэхэд 14,8% (n=4) АГ оношлогоо, 25,9% (n=7) АГ эмчилгээ, 51,8% (n=14) АГ-г хянах үйл ажиллагааг тус тус хангалтгүй хийж байна. (p<0.0001). Судалгаанд хамрагдсан нийт үйлчлүүлэгчдийн дундаж нас 37,7(±13,6), 60,8%(n=113)-ийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд 66,6% (n=124) дээд боловсролтой бол 33,4% (n=62) нь тусгай дундаас доош боловсролтой байна (p=0.028). Өрхийн орлогыг 2017 онд үндэсний статистикийн хорооноос тогтоосон өрхийн дундаж орлого (848800 төгрөг)-той харьцуулахад 58,1% (n=108) бага орлоготой байв. Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийг Морицкийн асуумжаар үнэлэхэд 13,4% (n=25) сайн, 54,3% (n=101) дунд, 32,3% (n=60) хангалтгүй (p<0.0001) байсан ба 16,7% (n=31) зүрх судасны өвчний эрсдэлгүй байлаа.

Дүгнэлт: Артерийн гипертензитэй үйлчлүүлэгчдийн эмийн тогтвортой хэрэглээ нь хангалтгүй байна. Үүнд нөлөөлж буй шалтгаан нь эмч, үйлчлүүлэгч аль альнаас нь хамааралтай байна. ӨЭМТ-д ажиллаж буй эмч нарын АГ-ийг анхан шатны тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, АГ-ийн эмийн тогтвортой хэрэглээг нэмэгдүүлэхийн тулд АГ-ийг хянах үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

Түлхүүр үг: Артерийн гипертензи, эмийн тогтвортой хэрэглээ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААН СЭТГҮҮЛ

Study on medication adherence among arterial hypertension patients of family healthcare centers in Ulaanbaatar

Baljinnyam S[1], Myagmartseren D[1]

[1]MNUMS, School of Medicine, Department of Family Medicine

Introduction: The most common cause of death in the population has become the non-communicable diseases, with increasing cases each year. The World Health Organization estimates that stroke and heart attack are among the ten leading causes of non-communicable diseases, which are arterial hypertension. In Mongolia, the prevalence of arterial hypertension and its risk factors were studied, but the monitoring of treatment results, medical adherence, and the factors for them have not been studied within the scope of Family Healthcare Center (FHC), which is the main reason of conducting this study.

Purpose: Study of medication adherence among arterial hypertension patients of family healthcare centers in Ulaanbaatar.

Materials and methods: The study was conducted between May and August 2019 using the cross-sectional prospective model of analytical study. A simple random sampling was collected from 27 FHCs' physicians of 9 districts of Ulaanbaatar, MAP assessed with 3 groups of 11 questions, and the 186 patients of those FHCs were evaluated using Morizky scale questionnaire consisting of 4 groups of 36 questions, and the collected data were assessed using the STATA 12 software. The value of the 'p' result is considered statistically significant when it is lower than 0.05.

Results: The average age of physicians (standard deviation) was 28.9 (1.1) and 85.2% (n = 23) were female. The total number of physicians were assessed by MAP method, 14.8% (n = 4), 25.9% (n = 7), 51.8% (n = 14) of physicians were not performing up to the standards the arterial hypertension diagnosis, treatment and monitoring respectively. ($p < 0.0001$). The average age of total survey patients was 37.7 (± 13.6), of which 60.8% (n = 113) are females, 66.6% (n = 124) had a university degree and 33.4% (n = 62) had a lower than secondary education.($p=0.028$), 58.1% (n = 108) of respondents had lower income than the average household income (MNT 848,800) set by the National Statistical Office in 2017. When respondents were assessed by Morizky scale, 13.4% (n = 25) was good, 54.3% (n = 101) was medium, 32.3% (n = 60) was not satisfactory. ($p < 0.0001$). 16.7% (n = 31) had no risk of cardiovascular disease.

Conclusion: The medication adherence of arterial hypertensions patients is not satisfactory. It is dependent on both physicians and patients. Furthermore, it is necessary to improve the management of arterial hypertension monitoring in order to improve the quality of primary care provided by physicians at the FHCs and the medication adherence of arterial hypertensive drugs in the FHC.

Keywords: Arterial hypertension, medication adherence.